











ДАРЬГАНГЫН БЦГ- ЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРЫН СУДАЛГАА ТХГН-ЫН СОЁЛЫН ӨВ, БАЙГАЛИЙН  
ДУРСГАЛТ БОЛОН ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗРУУДЫН СУДАЛГАА



2018.03.27

№	СУ М	ХӨШӨӨ ДУРСГАЛЫН ТОО		ЗУРАГ	ТАЙЛБАР
1.	Дарьганга	1. Хонгор овооны хүн хөрөг	N 45,22,404 E 113,54,308		Сумаас зүүн тийш 15 км-т, хойд урд Хөөвөр нуурын баруун биед Хонгор толгойн ар шил дээр багавтар чулуун байгууламжийн дунд нэгэн хүн чулуун хөшөө бий. Энэхүү хөшөөг галт уулын гаралтай хар саарал өнгийн хүрмэн чулуугаар үйлджээ.
2.	Дарьганга	1. Хөргийн хөндийн 1 дүгээр хөрөг / толгойгүй /	N 45,22.40,4 E 113,54.3,08		1-р хүн чулуун хөшөө. Уг хөшөөг хар саарал өнгийн галт уулын гаралтай хүрмэн чулуугаар үйлджээ.  Сумын төвөөс зүүн тийш 56 км “Хөргийн хөндий гэдэг газар байрладаг.  УИХ-ын 2004.04.29-ны 22 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авсан.
3	Дарьганга	2. Хөргийн хөндийн 2 дугаар хөрөг	N 45 <sup>0</sup> 33'09,9" E 114 <sup>0</sup> 13'58,1"		2-р хүн чулуун хөшөө. Уг хөшөөг мөн л хар саарал өнгийн хүрмэн чулуугаар үйлджээ. Хөшөөнд баруун гартаа сав барьж хүйсний дээхнэ авсан, баруун гараа өвдөг дээр тохойлдон сул тавьсан суугаа хүний бүтэн сийлмэл дүрсийг гаргажээ.



4	Дарьганга	3. Хөргийн хөндийн 3 дугаар хөрөг	N 45°33'09,2" E114°13'57,3"		3-р хүн чулуун хөшөө. Энэхүү хүн чулуун хөшөөг галт уулын гаралтай хар саарал хүрмэн чулуугаар үйлджээ. Баруун мөрнөөс зүүн ташааны дээд хэсэг хүртэл тууш хугарч хоёр хэсэг болсон байдалтай байна. Хөшөөнд баруун гартаа сав барьж гэдэсний орчимд авсан баруун гараа сул унжуулсан хүний төрхийг гаргажээ.
5	Дарьганга	4.Хөргийн хөндийн 4 дүгээр хөрөг	N 45°32'55,2" E114°13'57,7"		4-р хүн чулуун хөшөө. Энэхүү хүн чулуун хөшөөг галт уулын гаралтай хар саарал хүрмэн чулуугаар үйлджээ. Хөшөөний гадаргуу нэлэхийдээ өгөршиж муудсан тул дүрслэлүүд нь нэлээд бүдгэрсэн харагдана. Цээжээрээ хоёр хэсэг хуваагдсан байдалтай байна
6	Дарьганга	5.Хөргийн хөндийн 5 дугаар хөрөг / толгойгүй /	N 45°33'36,3" E114°14'26,5"		5-р хүн чулуун хөшөө. Энэхүү хүн чулуун хөшөөг саарал өнгийн том ширхэгтэй боржин чулуугаар үйлджээ. Хөшөөнд баруун гартаа цөгц хэлбэрийн савыг ёроолоос нь барьж цээжиндээ авсан, зүүн гараа зүүн өвдөг дээрээ тавьсан суугаа хүний төрхийг гаргажээ. Толгойн хэсэг хүзүүгээрээ хугарсан боловч эвээрээ нийлж байна.





7	Дарьганга	6.Хөргийн хөндийн 6 дугаар хөрөг	N 45°33'36,3" E114°14'26,5"		<p>6-р хүн чулуун хөшөө. Энэхүү хүн чулуун хөшөөг саарал өнгийн том ширхэгтэй боржин чулуугаар үйлджээ. Хөшөөнд баруун гараа хэвлий хэсэгтээ байрлуулсан , зүүн гараа зүүн өвдөг дээрээ тавьсан байдалтай байна.</p>
8.	Дарьганга	1.Гөхлийн ширээний 1 дүгээр хөрөг	N 45°35'17,2" E114°15'09,5"		<p>Сумын төвөөс зүүн хойш 50 гаруй км-т, Хөргийн хөндийн зүүн бие, Баянцагаан уулын баруун хөндий, Бичигтийн хавцлаас зүүн хойш 3 орчим км-т, Гөхөлийн ширээ хэмээх газар өөр хоорондоо 50 орчим м-ийн зайтай орших 2 хүн чулуун хөшөө байна. Эдгээр хөшөө нь эрт цагт тоногдсон болов уу гэлтэй чулуун овоолгын дунд оршино.</p> <p>1-р хүн чулуун хөшөө. Урд талынх нь. Энэхүү хөшөөг галт уулын гаралтай үнсэн саарал өнгийн хүрмэн чулуугаар үйлджээ.</p>

9	Дарьганга	2. Гөхлийн ширээний 1 дүгээр хөрөг	N 45°35'15,7" E114°15'09,6"		<p>Сумын төвөөс зүүн хойш 50 гаруй км-т, Хөргийн хөндийн зүүн бие, Баянцагаан уулын баруун хөндий, Бичигтийн хавцлаас зүүн хойш 3 орчим км-т, Гөхөлийн ширээ хэмээх газар өөр хоорондоо 50 орчим м-ийн зайтай орших 2 хүн чулуун хөшөө байна. Эдгээр хөшөө нь эрт цагт тоногдсон болов уу гэлтэй чулуун овоолгын дунд оршино.</p> <p>2-р хүн чулуун хөшөө. Хойд талынх нь энэхүү хөшөөг үнсэн саарал өнгийн хүрмэн чулуугаар үйлджээ. Хөшөөнд хоёр гартаа сав барьж хэвлий орчмоо барьсан суугаа хүний хөргийг дүрсэлжээ.</p>
10	Дарьганга	Ламтын заставын 1 дүгээр /эм/	N 45°12'27,8" E114°04'10,2"		<p>Сумаас зүүн урагш 45 км-т, Ламт хэмээх багавтар уулын баруун дор, Ламтын заставын баруун урд 200-д м-т 3 хүн чулуун хөшөө бий.</p> <p>1-р хүн чулуун хөшөө. Энэхүү хүн чулуун хөшөөг шаргал өнгийн элсэн чулуугаар үйлджээ. Хөшөөнд баруун гартаа өндөр сав барьж цээжиндээ авсан зүүн гараа өвдөг дээрээ тавьсан суугаа хүний бүтэн биеийн дүрслэл бүхий хөшөө байна.</p>





11	Дарьганга	Ламтын заставын 2 дугаар хөрөг / эр	N 45°12'27,8" E114°04'10,2"		<p>Сумаас зүүн урагш 45 км-т, Ламт хэмээх багавтар уулын баруун дор, Ламтын заставын баруун урд 200-д м-т 3 хүн чулуун хөшөө бий.</p> <p>2-р хүн чулуун хөшөө. Энэхүү хөшөөг шаргал өнгийн элсэн чулуугаар үйлджээ. Баруун гартаа сав барьж цээжиндээ авсан зүүн гараа өвдөг дээрээ тавьсан байдалтай суугаа хүний хөргийг гаргажээ. Толгойд оройдоо жижиг товгортой бөмбөгөр малгайг зузаан хүрээтэй, нуруу даган унжсан урт залаатай малгай дүрсэлсэн байна. Өргөн дугуй нүүрэнд нүд, хамар, амыг тод бодитой дүрсэлсэн байна.</p>
12	УЦФФ	Ламтын заставын 2 дугаар хөрөг / эр			<p>Сумаас зүүн урагш 45 км-т, Ламт хэмээх багавтар уулын баруун дор, Ламтын заставын баруун урд 200-д м-т 3 хүн чулуун хөшөө бий.</p> <p>3-р хүн чулуун хөшөө. Энэхүү хөшөөг шаргалдуу өнгийн элсэн чулуугаар үйлджээ. Хөшөөний толгой нь хугарч унан алга болсон, баруун мөрнөөс зүүн ташаа хүртэл шулуун хагарсан байна. Зүүн ташаа орчимд дүрсэлсэн хавтаганы дээд хэсгийн үзүүр хугарч унан алга болжээ. Хөшөөнд баруун гартаа сав барьж цээжиндээ авсан, зүүн өвдөг дээрээ тавьсан суугаа хүний төрхийг гаргажээ.</p>




13	Дарьганга	1. Шувуутын хөрөг суугаа боржин	N 45,07,870 E114,13,173		<p>Сумын төвөөм урд зүгт 70км, Байшинтын заставаас баруун тийш 6-7 орчим км, Шувуут уулын зүүн урд доор байх нэгэн чулуун овоолго бүхий байгууламжийн дунд цээжнээс доош булагдсан хүн чулуун хөшөө байна. Уг хөшөөг цагаан саарал өнгийн боржин чулуугаар үйлджээ. Хөшөөнд баруун гартаа сав барьж цээжиндээ авсан зүүн гараа бүсэлхий орчмоо сул унжуулсан байдалтай хүний дүрсийг гаргажээ. Толгойд намхан дугариг малгай өмсгөж, хоёр чихний араар олон салаа сүлжиж дээш шуун боосон гэзгийг унжуулжээ.</p>
14	Дарьганга	Уулын хүрийн хүн чулуун хөшөө	N 45,09.06 E 114,01.41,9		<p>Сумаас зүүн урагш 30 гаруй км-т, Баяндулаан уулын хойд талд байрлана. Энэхүү хүн чулуун хөшөөг боржин чулуугаар үйлджээ. Наран ургах зүг харсан цээжнээс доош булагдсан хүн чулуун хөшөө. Хөшөөнд баруун гар нь хундага барьж цээжиндээ авсан зүүн гараа доош унжуулсан. Толгойд намхан дугариг малгай өмссөн чихний араар олон салаа сүлжсэн гэзгийг унжуулсан.</p>
15	Дарьганга	Алтан овооны Бэр хөрөг	N 45°18'29,3" E113°51'31,9"		<p>1-р хүн чулуун хөшөө. Энэхүү хөшөөг улаан хүрэн өнгийн хүрмэн чулуугаар үйлджээ. Нутгийн иргэд бэр хөрөг хэмээн нэрлэдэг. Хөшөөнд баруун гартаа сав барьж цээжиндээ авсан, зүүн гараа өвдөг дээр тавьсан байдалтай суугаа хүний хөргийг гаргасан байна. Толгойн хэсэг нэлээд навтгар байдалтай.</p>



16	Дарьганга	Алтан овооны хүү хөрөг	N 45°33'36,3" E114°14'26,5"		2-р хүн чулуун хөшөө. Энэхүү хүн чулуун хөшөөг саарал өнгийн хүрмэн чулуугаар үйлджээ. Нутгийн иргэд энэ хөргийг хүү хөрөг хэмээн нэрлэдэг. Хөшөөний гадна тал ерөнхийдөө муудсан тул дүрслэлүүд нь тэр бүр сайн ялгагдахгүй болсон.
17	Дарьганга	Алтан овооны Хатан хөрөг			3-р хүн чулуун хөшөө. Энэхүү хөшөөг шаргал өнгийн боржин чулуугаар үйлджээ. Нутгийн иргэд энэхүү хөшөөг хатан хөрөг хэмээн нэрлэдэг. Хөшөөнд баруун гартаа хундага барьж цээжиндээ авсан, зүүн гараа өвдөг дээрээ тавьсан суугаа хүнийг сийлбэрлэн урласан байна.
18	Дарьганга	Алтан овооны Хаан хөрөг			4-р хүн чулуун хөшөө. Энэхүү хөшөөг цагаан саарал өнгийн гантиг чулуугаар үйлджээ. Нутгийн иргэд хаан хөрөг хэмээн нэрлэдэг. Хатан хөрөгтэйгээ зэрэгцэн оршино. Хөргийг сандал дээр сууж байгаагаар ур хийц сайтай бүтээсэн байна.
19	Дарьганга	Ар булгийн чулуун зэвсгийн дурсгалт газар	N 45°18'27,0" E113°45'42,1"		Сумаас баруун тийш 9-10 орчим км-т Молцог элсний хойд талд байна. Нурсан элсний эрэг байна. Ойр орчмоос нь өнгө өнгийн чулуун ялтас ил гарсан харагдана.


20	Дарьганга	Бургасан дуганы туурь	N 45012'27,8" E 114004'10,2"		Сумын төвөөс зүүн урагш 30 км-т Их бургасны хүр хэмээх газар байна. Чулууг зөөгөөд ашиглаж дууссан ул мөргүй алга болсон хэмжилт хийх боломжгүй болсон.
21	Дарьганга	Молцог элсний чулуун зэвсгийн дурсгалт газар	N 45°11'44,5" E 113°41'49,6"		Сумаас баруун урагш 25 км-т, Молцог элсний энгэрт байна. Ургамлын бүрхүүл бий болсон тул үзэгдэх муутай. Ямарнэгэн дурсгал ил гараагүй. Элсэн дунд эрэглэсэн хонхор байна.
22	Дарьганга	Вааран хавцлын булшнууд	N 45°23'141", E 113°47'054-		Сумын төвөөс баруун хойш байх Вааран хавцлын зүүн дээрээс доош уруудсан байдалтай чулуун овоолготой олон тооны булш байна. Бидний тоолсноор 176 булш байна.
23	Дарьганга	Нартын агуйнууд	N 45°28'17,3" E 113°39'21,2"		Сумын төвөөс хойд зүгт 30 орчим км-т, Нарт хэмээх ууланд байрлана. Нартын уулын зүүн болон баруун энгэрийн дагуу зүүн, зүүн урагш, баруун тийш харсан амтай 3 гүн биш агуй байна.



24	Дарьганга	Дуутын чулуун зэвсгийн дурсгалт газар	N 45°17'45,2" E 113°47'03,5"		Сумаас баруун тийш 6-7 орчим км-т Алтан овооны баруун дээр, Дуут нуурын баруун хойно байна. Мөн л нурсан элсэн эрэг шиг зүйл л харагдана. Энэхүү дурсгалт газраар өнгө өнгийн иртэй чулуу харагдана.
25	Дарьганга	Гангын цагаан овооны булшнууд			Сумын төвөөс зүүн зүгт 30-д км-т байх Гангын цагаан овоо хэмээх өндөр овооны оройгоор 3 булш байна. Булшнуудын хэлбэр зохиомж алдагдсан.
26	Дарьганга	Рашаантийн хийдийн туурь	N 45°21'9.23" E- 113°43'28.5"		Сумын төвөөс баруун хойд зүгт 12 км-т Рашаантын ухаагийн урд энгэрт Рашаантын хийдийн туурь байна. Энэ туурийн орчмоос олон тооны барилгын ор мөр байна. Зарим томоохон барилгын туурь нь гадуураа шороон далан, сувагтай байсан ажээ.
27	Дарьганга	Ганга нуурын булшнууд			Сумаас зүүн урагш 5 км-т Ганга нуурын хойд эргээр 4 булш байна.

28	Дарьганга	Эрээн хошууны булш	N 45°23'7.68" E113°41'8.56"		<p>Сумаас хойш 17 орчим км, Эрээн хошууны урд бие, Уулзварын голын хойд эрэг дээр нэгэн том булш байна. Булшны анхны хэлбэр алдагдсан. Гол нь хонхойсон. Том хэмжээний чулуун тойруулгатай.</p>
29	Дарьганга	Овоотын хийдийн туурь	N 45°17'16.3" E113°51'0.08"		<p>Сумын төвийн баруун урд хуучны хийдийн туурь байхыг нутгийн иргэд Овоотын хийдийн туурь хэмээн нэрлэдэг. Энэхүү хийдийн туурь нь нэлээд том талбайг эзлэн орших бөгөөд ул мөр гэх зүйлгүй арилсан. Голд нь морины сужигтай баруун хойно зорь ухсан. Нутгийн иргэд тоосгыг зөөн ашиглаж ирсэн байна. Ор мөргүй болсон учраас хэмжилт хийх боломжгүй болсон байна</p>
30	Дарьганга	Луйн голын булшнууд	N 45°23'54,2" E113°44'29,9"		<p>Сумаас хойш 20 орчим км-т Өлгий хадны урд, Луйн голын хойд талд 2 том булш байна. Энэхүү булшнуудыг бид шинээр бүртгэлээ.</p>

31	Дарьганга	Сүмтийн буюу Гуулин хотын туурь	N 45°12'7.93" E113°53'50,5"		Сумын төвөөс баруун урагш 15 орчим км-т Молцог элсний урд зах Сүмтийн нуурын зүүн хойд эрэг, Сүмтийн Хар толгойн хойд биед эртний барилгын хэд хэдэн туурь бий. Нутгийнхан уг туурийг Гуулин хотын туурь хэмээн нэрлэдэг. Туурийн орчимд 3 том барилгын үлдэгдэл орчмоос дөрвөлжин тоосго, дээврийн тосгуур, нөмрөг, нүүр ваар зэрэг барилгын хэрэглэгдэхүүн элбэг харагдана.
32	Наран	Бургасан дуганы туурь Сумаас урагш 30 км	N 45°12'27,8" E114°04'10,2"		
33	Наран	Мандалын хүн чулуун хөшөө – 1 Сумаас 12 км	N 45°08'06,9" E113,54'10,2"		
34	Наран	Мандалын хүн чулуун хөшөө – 2 Сумаас 12 км	N 45°08'06,9" E113°54'10,2"		

35	Наран	Молцог элсний туурь Сумаас 7 км	N45 09'43,4" E113 47'15,9"		
----	-------	---------------------------------------	-------------------------------	--	--

СУДАЛГААГ НЭГТГЭСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Ц. ОЮУНГЭРЭЛ